InvesCore
САНХҮҮГИЙН ГРУПП

# 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



“ИНВЕСКОР ББСБ” ХК
/НЭГТГЭСЭН/

# ГОЛ АМЖИЛТУУД

- ✓ 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгээ дэлхийн Топ-5 аудитын фирмийн нэг болох “БДО Аудит”-р баталгаажуулсан.
- ✓ Чанарын удирдлага (ISO9001) болон мэдээллийн аюулгүй байдлын (ISO27001) стандартыг нэвтрүүлж эхэлсэн.
- ✓ Нэгж хувьцаанд 17 төгрөг буюу нийт 1.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигч нартаа тараасан.
- ✓ 2021 оны 4 сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа цахим хэлбэрээр зохион байгуулсан.
- ✓ “Инвескор ББСБ” ХК нь Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС)-нд үндсэн гишүүнээр элссэн.
- ✓ Хувийн хэвшлийн түүхэн дэх хамгийн том бөгөөд анхны нээлттэй бондын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.
- ✓ “Инвескор Хэтэвч ББСБ” ХХК нь өөрийн Покет платформыг “Market Place” хэлбэрт шилжүүлж бусад ББСБ-уудад санал болгож эхэллээ.
- ✓ “Инвескор Санхүүгийн Групп” нь Токио-2020 зуны олимпын наадмын шууд дамжуулалтын “Алтан Ивээн Тэтгэгч”-р ажиллаж байна.






# БОНДЫН ХӨТӨЛБӨР

| | |
|---|---|
| Хөтөлбөрийн нийт үнийн дүн | 20.0 тэрбум төгрөг хүртэлх |
| Нэгж бондын нэрлэсэн үнэ | 100,000 төгрөг |
| Нийт тоо, ширхэг | 200,000 ширхэг хүртэлх |
| Анхдагч зах зээлийн хуваарь | 6 сарын дотор гурван Транчид хуваагдаж гарна |
| Бондын хугацаа | 24 сар |
| Бондын хүү (жилийн) | 12 - 14% |
| Хүү төлөх давтамж | Хагас жил тутам |
| Үндсэн төлбөр төлөх давтамж | Хугацааны эцэст |
| Бондын зарцуулалт | Бизнесийн зээл 11 тэрбум /55%/, хэрэглээний зээл 9 тэрбум /45%/ |
| Бондын барьцаа | "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн эзэмшиж буй Үнэт цаас гаргагчийн 12,000,000 ширхэг энгийн хувьцаа |
| Бондын эргэн төлөлт | Үнэт цаас гаргагчийн хүү, шимтгэлийн орлого болон харилцагчдад олгосон зээлийн үндсэн төлбөр |




*(2 жилийн хугацаатай банкны хадгаламжуудыг Инвескор бондтой 2021.06.30 байдлаар харьцууллаа)*

Бондын Транч I:

- Бондын жилийн хүүг 13%-р тогтоосон. Үнийн дүн нь 8 тэрбум төгрөг
- Анхдагч зах зээлийн арилжаа 06.14 –06.16 өдрүүдэд явагдсан.
- Анхдагч зах зээлийн захиалга 176%-р давж биелсэн бөгөөд бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаа эхлүүлэх зөвшөөрлийг 06.21-нд олгосон байна.

# ХУВЬЦААНЫ АРИЛЖАА




- ✓ 2021.06.30 байдлаар Инвескор ББСБ ХК-ийн хувьцааны ханш өмнөх оны мөн үеэс 24% хувиар өсч 3117 төгрөгт хүрсэн байна.
- ✓ IPO хийсэн цагаас хойш хувьцааны ханш нийт 95% хувиар өссөн амжилттай байна.
- ✓ Зах зээлийн үнэлгээ /2021.06.30/: 223.6 тэрбум төгрөг
- ✓ Нийт арилжаалагдсан ширхэг (2021 оны эхний хагас): 1,507,205
- ✓ Нийт арилжаалагдсан дүн (2021 оны эхний хагас): 4.2 тэрбум төгрөг
- ✓ Өдрийн дундаж дүн (2021 оны эхний хагас): 33.9 сая төгрөг

# БОРЛУУЛАЛТЫН СУВАГ




- 2021 оны эхний хагас жилд бид шинээр 4 салбар байгуулж нийт 17 салбартай болсон бөгөөд 15 нь Улаанбаатар хотод, 1 нь Эрдэнэт хотод, 1 нь цахим хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.
- Шинээр нээгдсэн салбарууд: Авто Экспо (Уран Ган авто худалдааны төвийн хажууд), Ривер Гарден, Хүннү Молл
- 2021 оны 2-р хагаст шинээр 4 салбар нээх төлөвлөгөөтэй ажиллаж байна.




- Инвескор Аллианс хөтөлбөр нь орон нутгийн ББСБ-уудыг чадавхжуулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх зорилготой ба одоогийн байдлаар Өмнөговь болон Дорнод аймгийн ББСБ нар уг хөтөлбөрийн гишүүнээр элсээд байна.
- Инвескор ББСБ ХК нь орон нутгийн ББСБ-удыг чадавхижуулж, шаардлагатай эх үүсвэрийг хангаж ажилласнаар орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

# КИРГИЗ УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

- ✓ "Инвескор ББСБ" ХК нь Монголтой соёл болон бусад зүйлээрээ адил төстэй хөгжиж буй орнуудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ экспортлох бодлого баримталдаг.
- ✓ Төв Азийн хөгжиж буй орнуудын зах зээлд өөрсдийн амжилт туршлага, финтек бүтээгдэхүүн, санхүүгийн тогтвортой эх үүсвэрийн давуу талаа ашиглан, салбар компани байгуулах төлөвлөгөөний дагуу Киргиз Улсад хоёр охин компани байгуулж, үйл ажиллагааг нь амжилттай эхлүүлээд байна.
- ✓ Киргиз улс дахь охин компани болох "Золотой Стандарт" бичил зээлийн байгууллага нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 500 гаруй харилцагчдын 4.6 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байна.
- ✓ "Золотой Стандарт" бичил зээлийн байгууллага нь тайлант хугацаанд анхны дэд оффисоо нээсэн бөгөөд оны 2-р хагаст нэг шинэ салбар, хоёр дэд оффис нээх төлөвлөгөөтэй байна.
- ✓ Мөн Киргиз улс дахь охин компани "Покет КГ" ХХК нь Финтект суурилсан Покет платформыг Киргизийн зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр харилцагч нарт цахим хэтэвч, төлбөр тооцоо, онлайн зээлийн үйлчилгээг саадгүй хүргэж эхлэх юм.







# ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

**Зээлийн багц (сая төгрөг)**




- 2021.06.30 байдлаар нийт зээлийн багц өмнөх оны мөн үеэс 64 хувиар өсч 121.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- Нэг зээлдэгчид ноогдох зээлийн хэмжээ 2.3 сая төгрөг байгаа нь зээлийн эрсдэл буурах гол хүчин зүйл болж байна.

**Зээлийн эргэн төлөлт ба олголт (сая төгрөг)***




- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээл эргэн төлөлтийн дүн 138 хувиар, зээл олголтын дүн 128 хувиар тус тус өсчээ.
- Цар тахлын хүнд цаг үед бид сегментэд суурилсан нэлттэй борлуулалтын тактикийг баримталж ажилласан.
- Үүний үр дүнд зээлийн эрсдлээ зохистой түвшинд хадгалахын хажуугаар зээл олголт болон зээлийн багцаа өсгөж чадлаа.

*оны эхнээс өссөн дүнгээр

# ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

**Зээлийн багц, бүтээгдэхүүнээр**




- 2021 онд хэрэглээний зээлийн процессыг автоматжуулж бизнесийн зээл рүү илүү чиглэж ажиллах ба ногоон зээл болон ЖДҮ-н санхүүжилтийг онцгой анхаарна..
- Бизнесийн харилцагч нарт бид зөвхөн санхүүжилт олгохоос гадна сургалт, зөвлөх үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж харилцагчаа дэмжиж ажилласаар ирсэн.
- 2018 оноос хойш нийт 100 гаруй харилцагчдад 4640 цагийн сургалт, зөвлөгөөг үнэ төлбөргүй үзүүлсэн байна.

**Зээлийн багцын чанар**




- “Инвескор ББСБ” ХК-н зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь санхүүгийн секторын хэмжээнд хамгийн бага түвшинд байна.
- Гол шалтгаан нь зээлийн судалгаа, олголтын үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан, мөн зээлийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хүний хүчин зүйлийг зохистой түвшинд хязгаарлаж, олон улсын түвшний скоринг системийг ашигладагт оршино.

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| сая ₮ | 2020.06.30 | 2021.06.30 |
|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 5,286 | 13,450 |
| Хөрөнгө оруулалт | 3,867 | 3,200 |
| Харилцагчдад олгосон зээл - цэвэр | 72,812 | 119,125 |
| *Зээлийн багц* | *74,350* | *121,830* |
| *Эрсдлийн сан* | *(1,538)* | *(2,705)* |
| Хуримтлагдсан хүүгийн авлага | 3,629 | 4,025 |
| Авлага | - | 4,244 |
| ӨБҮХХ | - | 1,147 |
| Бусад актив | 4,373 | 1,839 |
| Үндсэн ба биет бус хөрөнгө | 7,447 | 8,963 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **97,414** | **155,993** |
| Итгэлцлийн өглөг | 26,081 | 42,642 |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 16,348 | 16,715 |
| Бонд | - | 14,058 |
| Хуримтлагдсан хүүгийн өглөг | 2,370 | 4,600 |
| Бусад өглөг | 8,491 | 18,700 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **50,920** | **96,715** |
| Хувьцаат капитал | 16,282 | 16,282 |
| Нэмж төлөгдсөн капитал | 15,378 | 15,378 |
| Хуримтлагдсан ашиг | 14,833 | 27,618 |
| **НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **46,493** | **59,278** |

**Нийт хөрөнгө (сая төгрөг)**




**Өөрийн хөрөнгө (сая төгрөг)**



# ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| сая ₮* | 2020.06.30 | 2021.06.30 |
|---|---|---|
| **Хүүгийн орлого** | **11,679** | **15,685** |
| **Хүүгийн зардал** | **2,433** | **5,396** |
| Бусад хүүгийн зардал | 1,271 | 1,874 |
| Итгэлцлийн хүүгийн зардал | 1,162 | 3,522 |
| **Цэвэр хүүгийн орлого** | **9,246** | **10,289** |
| **Шимтгэл хураамжийн орлого** | **1,487** | **3,358** |
| **Үйл ажиллагааны зардал** | **3,856** | **5,184** |
| Хүний нөөцийн зардал | 1,348 | 2,717 |
| Үйл ажилллагааны бусад зардал | 2,508 | 2,467 |
| **Гадаад валютын ханшийн олз (гарз)** | **139** | **(107)** |
| **Зээлийн үнэ цэнэ бууралтын өмнөх ашиг** | **7,016** | **8,355** |
| Эрсдлийн сангийн зардал | 295 | 634 |
| Үйл ажиллагааны бус орлого (зардал) | - | 758 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **6,722** | **8,478** |
| Татварын зардал | 617 | 1,181 |
| **Цэвэр ашиг** | **6,105** | **7,297** |

*ОНЫ ЭХНЭЭС ӨССӨН ДҮНГЭЭР

**Хүү, шимтгэлийн орлого (сая төгрөг)**




**Цэвэр ашиг (сая төгрөг)**



# ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД (тусдаа)

| Шалгуур үзүүлэлт | Байх ёстой | 2020.06.30 | 2021.06.30 |
|---|---|---|---|
| 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-с доошгүй | 46.4% | 34.4% |
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-с доошгүй | 46.4% | 34.4% |
| 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-с доошгүй | 47.8% | 36.2% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-с дээш | 12.8% | 12.3% |
| Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө | 30%-с хэтрэхгүй | 8.5% | 14.9% |
| ББСБ-с гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 70%-с хэтрэхгүй | 0.0% | 0.0% |
| Нийт холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө | 25%-с хэтрэхгүй | 0.6% | 0.6% |
| Нэг холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө | 10%-с хэтрэхгүй | 0.1% | 0.0% |
| Үнэт цаасны эзэмшил / өөрийн хөрөнгө | 50%-с хэтрэхгүй | 15.5% | 14.6% |
| Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | +/-40%-с хэтрэхгүй | 5.7% | 22.1% |
| Итгэлцлийн өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 80%-с хэтрэхгүй | 53.2% | 77.3% |
| Өрийн бичгийн зохистой харьцаа | 50%-с хэтрэхгүй | 6.0% | 25.5% |
| Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 15%-с хэтрэхгүй | 5.2% | 3.9% |

# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ







## Смарт Лос систем

- ✓ Зээл олголтын үйл ажиллагааг 80% автоматжуулсан
- ✓ Төрийн мэдээллийн ХУР систем болон Нийгмийн даатгалын мэдээллийн санд холбогдсон
- ✓ Зээлдэгчийн талаар 20 төрлийн мэдээлэл цуглуулдаг
- ✓ Зээлийн үйл ажиллагаанд хүний хүчин зүйлээс хамаарсан эрсдэлийг бууруулсан
- ✓ Зээл олголтын өмнөх болон явцын хяналтыг сайжруулж эрсдэлийг бууруулж байна

## Core Banking систем

- ✓ Үндсэн бүртгэлийн систем
- ✓ Харилцагчид зориулсан аппликэйшн
- ✓ Зохицуулагч байгууллагын шаардлагад нийцсэн
- ✓ Эрхийн зохицуулалт, хяналт
- ✓ Мэдээллийн аюулгүй байдал
- ✓ ERP системүүдтэй холбогдсон
- ✓ Дэлгэрэнгүй тайлан мэдээлэл, дашбоард
- ✓ Мэдээллийн нөөцлөлт (backup)

## Кредит скорингийн систем

- ✓ Группын зэргэлдээ компани болох “Инвескор Эй Ай Лаб” ХХК хөгжүүлсэн
- ✓ Харилцагчийн үндсэн мэдээллүүд болон сэтгэлзүйн шинж чанаруудад тулгуурлаж шийдвэр гаргадаг
- ✓ Зээлийн эрх тогтоох үйл ажиллагаанд хүний оролцоог байхгүй болгосон
- ✓ Дижитал зээл болон хэрэглээний зээлийн эрх тогтоохдоо ашигладаг

# ПОКЕТ ПЛАТФОРМ – ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

## Pocket Loan

Покет цахим зээлийн үйлчилгээ
14, 30, 60 хоногийн хугацаатай зээл
55,000+ харилцагч

Зах зээлд нэвтэрсэн
2020.01.20

## Pocket Pay

Цахим төлбөр тооцооны үйлчилгээ
280,000+ харилцагч

Зах зээлд нэвтэрсэн
2020.01.20

## Pocket Coupon

Pocket аппликейшны харилцагчдад зориулсан урамшуулалтай бараа, үйлчилгээ худалдан авах үйлчилгээ
90%+ амжилттай борлуулалт

Зах зээлд нэвтэрсэн
2020.05.20

## Pocket Zero

30-90 хоногийн хугацаанд 2-6 хуваан төлөх боломжтой худалдан авалтын үйлчилгээ
100+ мерчант

Зах зээлд нэвтэрсэн
2020.10.08

*2020 оны онцлох бүтээгдэхүүн: Покет зеро 100+ брэнд, 100+ салбар*

*Түүнчлэн харилцагч нартаа зориулж төлбөрөө хуваалцах, чат, мөнгөтэй дугтуй илгээх, банкны карт холбох үйлчилгээг нэвтрүүлсэн.*

pocket

# ПОКЕТ ПЛАТФОРМ – ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

| Зээлдэгчийн байршил | Зээлийн дүн |
|---|---|
| Улаанбаатар хот,<br>21 аймаг | 20,000 төг –<br>10 сая.төг |

| Апп татан авалт | Харилцагчийн үйлчилгээ |
|---|---|
| 700,000+ | 2 харилцагчийн үйлчилгээний төв,<br>9+ салбар, хөдөлгөөнт цэг |

| Мэдээлэл дамжуулах суваг | Хүйсийн харьцаа |
|---|---|
| ✓ Чатбот<br>✓ Нийгмийн сүлжээ<br>✓ ХҮТ, салбар<br>✓ Хөдөлгөөнт цэг | 51:49<br>эмэгтэй : эрэгтэй |

✓ *Харилцагчийн үйлчилгээний төв 1, 2*




**175k +**
Хүнд мэдээлэл хүргэсэн

pocket

Available on the App Store

GET IT ON Google Play

✓ *Үзэсгэлэн, арга хэмжээнүүд*




✓ *Хөдөлгөөнт цэгүүд (олон нийтийн төвүүд)*




✓ Мөн дуудлагын төв, харилцагчийн үйлчилгээний төв болон ухаалаг чатбот, нийгмийн сүлжээний хуудсаар дамжуулан зээлийн бүтээгдэхүүн, төлбөр тооцоо, санхүүгийн зөвлөгөө үйлчилгээг орон зай, цаг хугацаа үл хамааран иргэдэд хүргэж байна.



InvesCore

САНХҮҮГИЙН ГРУПП

www.invescore.mn info@invescore.mn +976-7709-0077